



УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Г.САРАНТУЯА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/322
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ



УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Санхүүгийн Аудитын Газрын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг:
sambuunyamyam@audit.gov.mn

Эс Жи Эм Ди Аудит ХХК
Утас: 7000 6948
Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn,
ekhbayar@cra.mn

Үндэсний аудитын газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2017 оны 2 дугаар сарын 13-ны өдөр

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дүгээр заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2016//СТА-ГАК-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”байгууллагын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг хуулийн хугацаанд хийхээр төлөвлөн “Эс Жи Эм ДиАудит”ХХК-ийн аудиторууд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 20-нд “Эс Жи Эм ДиАудит”ХХК-нд ирүүлсэн байна.

“Эс Жи Эм ДиАудит”ХХК аудитыг хуулийн хугацаандгүйцэтгэж, аудитын тайланг “Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн” -гийн удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн төсвийн захирагч нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай”,“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”,“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”,“Шилэн дансны тухай”,“Нийгмийндаатгалынбагцхууль”,“Шинжлэх ухаан, технологийн

хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хувь хүний орлогын албан татварын хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлтөөрөө байна.

Гурав, Байгууллагын зорилго, зорилтууд, үйл ажиллагаа:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу “Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн захирал нь төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. “Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгодог.

Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн гол зорилго:

Эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан ус, цаг уур, уур амьсгал, байгаль орчны судалгааны болон бодит, урьдчилсан мэдээ, мэдээллээр үйлчлэхэд оршино.

Уг зорилгын хүрээнд тайлант хугацаанд дараах зорилтыг хэрэгжүүлэхээр тусгалаа. Үүнд:

- Ус цаг уур, уур амьсгал, байгаль орчны бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр төр засаг, нийгэм-эдийн засаг, хүн амын эрэлт хэрэгцээг хангах,
- Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний арга зүй, технологийг боловсруулах, үйлдвэрлэлийн туршилт хийх,
- Ус цаг уур, уур амьсгал, байгаль орчин, тандан судалгаа, мэдээллийн технологийн чиглэлээр судалгаа хийх, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, технологи, төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, оролцох, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж, үнэлгээ гаргах,
- Дэлхийн ажиглалтын бүлэг, Дэлхийн цаг уурын байгууллага болон бусад улс орон, олон улсын холбогдох хөтөлбөр, гэрээ, хэлэлцээртэй үйл ажиллагаа уялдуулах,
- Дэлхийн цаг уурын байгууллагын мэдээллийн сүлжээн дэх цаг уурын холбооны үндэсний төвийн үүргийг гүйцэтгэх,
- Зайнаас тандан судлах үндэсний төвийн үүргийг гүйцэтгэх,
- Байгаль орчны мэдээллийн төвийн үүргийг гүйцэтгэж, мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх,
- Ажлын ачааллыг нягтруулах, сайжруулах, технологийн зарим өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлэх,
- Мэдээлэл боловсруулалтын MSS системийг шинэчлэх, суперкомпьютерийн хүчин чадлыг нэмэгдүүлэх,
- Байгаль орчны мэдээллийн сангуудыг бүрэн байгуулж дуусгах зэрэг зорилт тавин ажилласан байна.

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оныжилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахаар төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 21-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”нь санхүүгийн үйл ажиллагаандааБайгал орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны 3 дугаар сарын 3–ны өдрийн А/58дугаар тушаалаар баталсаннягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг мөрддөг. Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, зааврын дагуу санхүүгийн тайлангаа гаргаж байна.

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулгын аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэсэн. /ТАБ-СТА-В-2/

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийнAcolous 3.0 програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдал:

Төлөвлөлтийн үе шатанд ТАБ-СТА-А-1 маягтыг ашиглан материаллаг байдлын түвшинг тогтоохдоо нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэн.“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн нийт зардал сүүлийн 2 жилд дараалан буурч батлагдсан байдаг.

Гүйцэтгэлийн үе шатанд ТАБ-СТА-В-1 маягтыг ашиглан материаллаг байдлыг 0,5 хувиар буюу 7,085.6 мянган төгрөгөөр тооцох нь зүйтэй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах зорилгоор дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Ус цаг уур, орчны судалгаа

мэдээллийн хүрээлэн"-гийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 1,413,974.6 мянган төгрөг (үүнээс нэмэлт санхүүжилт 582,531.5 мянган төгрөг)-ийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны бус орлогоор 10,976.6 мянган төгрөг, өнгөрсөн оны буцаасан гүйлгээ 4,900.0 мянган төгрөгийн орлого олжээ. Урсгал зардалд 1,420,709.5 мянган төгрөг батлагдсанаас 1,417,115.2 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 3,594.3 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар судлаж үзэхэд shilendans.gov.mn сайтад 2016 онд нийт 121 мэдээлэл байршуулснаас 5,000.0 мянган төгрөгөөс дээш зардлын гүйлгээний 21 мэдээллийг байршуулсан байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 26 горим, сорил нарийвчилсан сорилыг гүйцэтгэв.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, худалдан авалт (бараа материал), өр төлбөр, төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого, бараа үйлчилгээний урсгал зардал, музейн үзмэр худалдан авах зэрэг дансны ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 41,5 хувь, мөнгөн хөрөнгийн 28,5 хувь, нийт зардлын 85.9 хувь, нийт хөрөнгийн 10 хувийг тус тус эзэлж байна.

**Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илэрхийлэгдээгүй байна.

Материаллаг дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

2016 онд Германы хамтын ажиллагааны олон улсын нийгэмлэг–GIZ байгууллагын санхүүжилтээр хамтын ажиллагааны хүрээнд хүрээлэнгийн сургалтын өрөөг тохижуулахад дэмжлэг үзүүлж, тус бүр нь 1,950.3 мянган төгрөгийн 16 ширхэг компьютер, 2,398.0 мянган төгрөгийн 1 ширхэг зөөврийн компьютер, 1 ширхэг дэлгэц зэрэг нийт 34,001.0 мянган төгрөгийн процессор, тусгай тоног төхөөрөмж 15,289.2 мянган төгрөгөөр буюу нийт 49,290.2 мянган төгрөгийн хоёр удаагийн худалдан авалт хийсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33.2.1 заалтыг зөрчсөн болно.

Шийдвэрлэсэн: Худалдан авахад хийхдээ **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай (ТБОНӨХБАҮХА) хуулийн 33.2.1** заалтыг дагаж мөрдөх, албан шаардлага өгөх.

Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

1. Ус Цаг Уур, Орчны Судалгаа Мэдээллийн Хүрээлэн судалгааны ажил, төслийн хөрөнгөөр авсан, бараа материал дээр бүртгэлтэй байгаа хөрөнгийг төслийн ажил дуусахад гэрээний дагуу үндсэн хөрөнгийн дансад бүртгэх шаардлагатай байна.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй, судалгааны ажил, төсөл хөтөлбөрүүдэд төслийн аудит хийх хэрэгтэй гэж үзэж байна.

**Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар
илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 2 байгууллага нэгдсэн үеийн ондамжсан дансны авлагын үлдэгдэл 591.4 мянган төгрөгийг төлүүлсэн, 7,270.9 мянган төгрөгийн дансны өглөгийн үлдэгдлийг барагдуулах, 9,708.0 мянган төгрөгийн тийз, хоолны

зардлын ангиллыг зөв бүртгэх нийт 16,978.9 мянган төгрөгийн зөвлөмж, худалдан авах ажиллагаанд 49,290.2 мянган төгрөгийн албан шаардлагыг тус тусхүргүүлэв.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оны санхүүгийн тайланд Эс Жи Эм Ди Аудит ХХК аудит хийсэн бөгөөд аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаар

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, хавсралтууд тус тус хавсаргав.



УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Мэдээ боловсруулах системийн талаар.....1

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

Асуудал 2

Авлага, өглөгийн талаар.....2

Тэргүүлэх ач холбогдол № 3 зүйлс:

Асуудал 3

Зардлын ангиллын талаар.....3

2017 оны 2дугаар сарын 13-ны өдөр

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн УТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой, харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн” УТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт:

Цаг уурын мэдээ боловсруулах GTS/MSS (Global Telecommunication System/ Message Switching System) систем нь Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Цаг уурын мэдээллийн системийг сайжруулах нь” нэртэй төслийн хүрээнд 2004 онд суурилагдсан. MSS систем үндсэн болон нөөцөөр сэлгэн ажиллах 2 сервертэй, ДЦУБ-ын бүсийн төвүүд болох Бээжин Новосибирсктэй мэдээ солилцох GTS 2 сервертэй (мөн сэлгэх зарчмаар ажилладаг) цогц шийдэгдсэн. Гэвч уг систем нь хоногийн 24 цагийн ажиллагаатайгаас гадна суурилуулагдснаас хойш насжилт 10 гаруй жил болсон тул системийн хэвийн ажиллагаа доголдож эхлээд байгаа билээ. Иймд **дэлхийн цаг уурын байгууллагын шаардлагад нийцсэн системийг шинээр солих зайлшгүй шаардлагатай байна.** Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, гэсэн заалтай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

- Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй байх,

ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, гэсэн заалтыг дагаж мөрдөж, хэрэгжүүлж, ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтануудад танилцуулж, баталгаажуулсан болно.

Асуудал 2: Авлага, өглөгийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №2****ҮАГ-ын ажиглалт:**

Тус хүрээлэн нь 591.4 мянган төгрөгийн авлагын, 7,270.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Эрсдэлүүд

- Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй байх,

Төсвийн захирагчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтануудад танилцуулж, баталгаажуулсан болно.

Асуудал 3: Зардлын ангиллын талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт:

Тус хүрээлэн нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж ангилалд Германы хамтын ажиллагааны олон улсын нийгэмлэг – GIZ байгууллагын санхүүжилтээр БНГУ руу томилолтоор явсан 2 ажилтаны нийт 9,708.0 мянган төгрөгийн тийз, хоолны зардлыг бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалуудтай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

- Толилуулга ба илчлэл батламж мэдэгдэл хангагдаагүй байх,
- Удирдлагад буруу мэдээлэл өгөх,

ҮАГ-ын зөвлөмж:

Зардлын ангиллыг үнэн зөвхийх, бүртгэж ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтануудад танилцуулж, баталгаажуулсан болно.

АУДИТХИЙГДСЭНСАНХҮҮГИЙН	БАЙДЛЫН	ТАЙЛАН
Үзүүлэлт	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0	0
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	0	0
АВЛАГА	93,126,351	591,438
Бусад авлага	93,126,351	591,438
БАРАА МАТЕРИАЛ	121,862,133	152,596,169
Хангамжийн материал	121,862,133	152,596,169
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	214,988,484	153,187,608
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	552,456,793	477,661,121
Биет хөрөнгө	532,921,589	472,143,695
Барилга, байгууламж	440,795,520	440,795,520
Хуримтлагдсан элэгдэл	-269,987,256	-277,333,848
Авто тээврийн хэрэгсэл	66,575,250	66,575,250
Хуримтлагдсан элэгдэл	-62,611,004	-63,719,454
Машин, тоног төхөөрөмж	1,247,472,995	1,319,356,695
Хуримтлагдсан элэгдэл	-960,078,227	-1,068,976,097
Тавилга, аж ахуйн эд хогшил	132,741,321	132,741,321
Хуримтлагдсан элэгдэл	-90,487,721	-101,277,643
Хэмжих шалгах багаж	23,293,802	23,293,802
Хуримтлагдсан элэгдэл	-11,898,694	-16,417,455
Номын фонд	15,871,298	15,871,298
Бусад үндсэн хөрөнгө	1,234,306	1,234,306
Биет бус хөрөнгө	19,535,204	5,517,427
Програм хангамж	179,548,099	179,548,099
Хасагдуулга	-160,012,895	-174,030,672
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	552,456,793	477,661,121
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	767,445,277	630,848,729
Богино хугацаат өр төлбөр	9,498,592	7,270,944
Өглөг	9,498,592	7,270,944
Ажиллагчидтай холбогдсон өглөг	845,569	845,569
Бусад өглөг	8,653,023	6,425,375
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	9,498,592	7,270,944
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	9,498,592	7,270,944
Өмнөх үеийн үр дүн	757,946,685	757,946,685
Тайлант үеийн үр дүн	0	-134,368,900
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	757,946,685	623,577,785
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	767,445,277	630,848,729

АУДИТХИЙГДСЭНСАНХҮҮГИЙННҮРДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАН	
	2015	2016
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Урсгал	1,384,993,300	1,413,974,600
Улсын төсвөөс	1,710,396,763	1,903,108,955
Нэмэлт санхүүжилтийн орлого	325,403,463	489,134,355
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	323,116,741	489,134,355
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,000	0
Төсвийн урамшуулал	2,241,722	0
Бараа, үйлчилгээний орлого	702,539,158	52,148,540
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	686,728,605	39,350,598
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	15,810,553	12,797,942
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	702,539,158	52,148,540
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,412,935,921	1,955,257,495
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,651,500,263	1,889,815,790
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	1,352,341,757	1,437,650,271
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,216,570,057	1,294,272,057
Цалин	1,216,570,057	1,294,272,057
Нийгмийн хамгааллын шимтгэл	135,771,700	143,378,214
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	114,002,909	121,813,426
Тэтгэврийн даатгалын шимтгэл	87,658,198	92,472,467
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	9,962,918	13,051,535
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	10,944,980	10,898,228
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	5,436,813	5,391,196
Эрүүл мэндийн даатгалын хураамж	21,768,791	21,564,788
Тогтмол зардал	79,802,927	93,834,546
Гэрэл цахилгааны зардал	75,666,188	93,834,546
Түлш, халаалтын зардал	3,145,321	0
Цэвэр, бохир усны зардал	401,418	0
Байрны түрээс	590,000	0
Хангамж, бараа материалын зардал	35,560,604	30,092,730
Бичиг хэргийн материал	14,664,455	14,533,343
Тээвэр, шатахууны зардал	8,104,887	5,743,612
Шуудан холбоо интернетийн төлбөр	6,043,342	7,897,983
Ном, хэвлэлийн зардал	289,660	0
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	6,458,261	1,917,791
Эд хогшил, урсгал засварын зардал	14,980,446	10,901,700
Багаж хэрэгсэл	4,628,900	403,100
Урсгал засвар	10,351,546	10,498,600
Томилолт, зочны зардал	122,140,232	42,009,919
Гадаад томилолтын зардал	27,164,445	1,199,900
Дотоод томилолтын зардал	94,975,787	40,810,019
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	36,969,131	128,647,252

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,205,931	123,889,547
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000	1,650,000
Даатгалын үйлчилгээний төлбөр	1,260,000	1,281,400
Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	20,000
Газрын төлбөр	356,400	356,400
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	646,800	1,449,905
Бараа үйлчилгээний бусад зардал	9,705,165	146,679,371
Бусад зардал	7,139,164	0
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,566,001	146,679,371
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,352,170	199,810,606
Бусад урсгал шилжүүлэг	115,352,170	199,810,606
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	54,446,262	0
Төвлөрүүлэх шилжүүлэг	44,023,378	167,797,924
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,882,530	28,098,682
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	0	3,914,000
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,766,852,433	2,089,626,395
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	646,083,488	-134,368,900
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	0	0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	0	0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	646,083,488	-134,368,900

АУДИТ ХИЙГДСЭНӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийнгазрынорүүлсанкапитал	Дахинүнэлгээнийнөөц	Хуримтлагдсанүрдүн	Засгийнгазрынхувьёоролцоонынийтдүн
1				
2				
3	2015 оны 1-р сарын 1-ээрх			
4	үлдэгдэл			
5	Нягтлан бодох бүртгэлийн			
6	бодлогын өөрчлөлт			
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
8	Үндсэн хөрөнгийн дахин			
9	үнэлгээний өсөлт			
10	Үндсэн хөрөнгийн дахин			
11	үнэлгээний бууралт			
12	Орлогын тайланд хүлээн			
13	зөвшөөрөөгүй олз гарз			
14	Тайлант үеийн үр дүн			
15				
16	2015 оны 12-р сарын 31-ээрх	757,946,684.7		
17	үлдэгдэл	6		757,946,684.76
18	Нягтлан бодох бүртгэлийн			
19	бодлогын өөрчлөлт			
20		757,946,684.7		
21	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6		757,946,684.76
22	Үндсэн хөрөнгийн дахин			
23	үнэлгээний өсөлт			
24	Үндсэн хөрөнгийн дахин			
25	үнэлгээний бууралт			
26	Орлогын тайланд хүлээн			
27	зөвшөөрөөгүй олз гарз			
28		(134,368,899.7		
29	Тайлант үеийн үр дүн	9)		(134,368,899.79)
30	2016 оны 12-р сарын 31-ээрх	623,577,784.9		
31	үлдэгдэл	7		623,577,784.97

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1	Тусламж, санхүүжилтын орлого	1,710,396,763	1,506,431,764
2	Улсын төсвөөс	1,384,993,300	1,413,974,600
3	Урсгал	1,384,993,300	1,413,974,600
10	Нэмэлт санхүүжилтийн орлого	325,403,463	92,457,164
11	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	323,116,741	0
14	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	0	87,557,164
15	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,000	4,900,000
16	Төсвийн урамшуулал	2,241,722	0
18	Бараа, үйлчилгээний орлого	152,505,498	500,102,006
20	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	152,505,498	500,102,006
22	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	14,854,779	10,967,651
23	Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	137,650,719	0
25	Бусад орлого	0	489,134,355
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,862,902,261	2,006,533,770
28	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,510,791,517	1,766,495,276
29	Ажиллагчидтай холбогдсон зардал	1,324,756,443	1,435,016,540
30	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,188,944,392	1,244,074,475
31	Цалин	1,188,944,392	1,244,074,475
33	Унаа хоолны хөнгөлөлт	52,576,000	50,596,000
36	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	135,812,051	140,346,065
37	Тэтгэврийн даатгалын шимтгэл	93,166,329	97,448,973
38	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	8,529,089	8,579,417
39	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	10,661,361	10,724,064
40	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,132,471	2,145,058
41	Эрүүл мэндийн даатгалын хураамж	21,322,801	21,448,553
42	Бараа үйлчилгээний урсгал зардал	186,035,074	331,478,736
43	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	72,140,746	101,326,669
44	Гэрэл цахилгааны зардал	68,004,007	101,326,669
45	Түлш, халаалтын зардал	3,145,321	0
46	Цэвэр, бохир усны зардал	401,418	0
47	Байрны түрээс	590,000	0
48	Хангамж, бараа материалын зардал	17,763,978	21,666,488
49	Бичиг хэрэг	2,842,688	4,721,870
50	Тээвэр, шатахуун	7,409,000	5,713,500
51	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,043,342	7,897,983
54	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,468,948	3,333,135
55	Нормативт зардал	60,000	577,000
58	Нормын хувцас, зөөлөн эдлэл	60,000	577,000
59	Эд хогшил, урсгал засварын зардал	18,353,070	62,256,905
60	Багаж техник хэрэгсэл	12,206,900	57,266,455

62	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	0	128,400
63	Урсгал засвар	6,146,170	4,862,050
64	Томилолт, зочны зардал	27,164,445	1,199,900
65	Гадаад албан томилолт	27,164,445	1,199,900
66	Дотоод албан томилолт	95,182,250	40,227,888
68	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,965,631	144,451,774
69	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	34,187,431	139,347,049
70	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000	1,650,000
71	Даатгалын үйлчилгээ	1,260,000	1,281,400
72	Тээврийн хэрэгслийн татвар	0	245,920
73	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	20,000
75	Газрын төлбөр	356,400	356,400
76	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	661,800	1,551,005
78	Бараа үйлчилгээний бусад зардал	12,587,204	0
79	Бараа үйлчилгээний бусад зардал	12,587,204	0
91	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,285,292	32,012,682
95	Бусад урсгал шилжүүлэг	72,285,292	32,012,682
98	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	55,402,762	0
101	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,882,530	28,098,682
103	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	0	3,914,000
104	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	1,583,076,809	1,838,735,846
105	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	279,825,452	258,621,812
106	Хөрөнгийн орлого	0	0
123	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0	0
131	Засгийн газрын бондын үндсэн төлбөр	0	0
132	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр	0	0
134	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	279,825,452	258,621,812
135	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2.23517E-08	0
136	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2.38419E-07	9.53674E-07

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,420,709,500	2,001,633,770	-580,924,270	140.88
2	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,420,709,500	2,001,633,770	-580,924,270	140.88
3	IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,420,709,500	2,001,633,770	-580,924,270	140.88
4	Бараа, үйлчилгээний зардал	1,385,843,400	1,805,737,165	-419,893,765	130.29
	Цалин хөлс болон нэмэгдэл				
5	урамшил	1,078,426,000	1,293,684,475	-215,258,475	119.96
6	Үндсэн цалин	1,027,830,000	1,243,088,475	-215,258,475	120.94
8	Унаа, болон бусад нөхөн олговор	50,596,000	50,596,000	0	100
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд				
11	төлөх шимтгэл	117,967,000	140,346,065	-22,379,065	118.97
12	Тэтгэврийн даатгал	75,069,908	97,448,973	-22,379,065	129.81
13	Тэтгэмжийн даатгал	8,579,417	8,579,417	0	100
14	ҮОМШӨ ний даатгал	10,724,064	10,724,064	0	100
15	Ажилгүйдлийн даатгал	2,145,058	2,145,058	0	100
	Байгууллага төлөх ЭМД ийн				
16	хураамж	21,448,553	21,448,553	0	100

17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,356,300	101,326,669	-1,970,369	101.98
18	Гэрэл цахилгаан	99,356,300	101,326,669	-1,970,369	101.98
22	Хангамж, бараа материалын зардал	14,732,300	21,666,488	-6,934,188	147.06
23	Бичиг хэрэг	3,772,100	4,721,870	-949,770	125.17
24	Тээвэр (шатахуун)	3,140,200	5,713,500	-2,573,300	181.94
25	Шуудан холбоо	6,479,200	7,897,983	-1,418,783	121.89
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,340,800	3,333,135	-1,992,335	248.59
29	Нормативт зардал	577,600	577,000	600	99.89
32	Нормын хувцас зөөлөн эдлэл	577,600	577,000	600	99.89
33	Эд хогшил худалдан авах	6,825,900	62,256,905	-55,431,005	912.06
34	Багаж, техник, хэрэгсэл	3,650,600	57,266,455	-53,615,855	1568.6
36	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	129,600	128,400	1,200	99.07
37	Урсгал засвар	3,045,700	4,862,050	-1,816,350	159.63
38	Томилолт, зочны зардал	5,675,900	41,427,788	-35,751,888	729.88
39	Гадаад албан томилолт	0	1,199,900	-1,199,900	0
40	Дотоод албан томилолт	5,675,900	40,227,888	-34,551,988	708.74
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	62,282,400	144,451,774	-82,169,374	231.93
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,245,000	139,347,049	-83,102,049	247.75
42	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,650,000	1,650,000	0	100
43	Даатгалын үйлчилгээ	1,281,400	1,281,400	0	100
44	Тээврийн хэрэгслийн татвар	259,600	245,920	13,680	94.7303544
45	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000	20,000	0	100
47	Газрын төлбөр	356,400	356,400	0	100
48	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,470,000	1,551,005	918,995	62.79
56	ТАТААС	34,866,100	28,098,682	6,767,418	80.59
59	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	167,797,924	-167,797,924	0
60	Засгийн газар хоорондын шилжүүлэг	0	167,797,924	-167,797,924	0
61	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	167,797,924	-167,797,924	0
63	Бусад урсгал шилжүүлэг	34,866,100	28,098,682	6,767,418	80.59
69	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,866,100	28,098,682	6,767,418	80.59
86	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	986,320,800	2,001,633,770	1,015,312,970	202.93
92	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,990,000	10,967,651	-4,977,651	183.09
93	Бусад орлого	0	489,134,355	-489,134,355	0
95	Төсвөөс санхүүжих	980,330,800	1,413,974,600	-433,643,800	144.23
99	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	87,557,164	-87,557,164	0
103	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0	0
104	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	0	0
105	БАЙГУУЛЛАГЫН ТОО				0
106	АЖИЛЛАГСАД БҮГД	119	119	0	100
107	Удирдах ажилтан	10	10	0	100
108	Гүйцэтгэх ажилтан	98	98	0	100
109	Үйлчлэх ажилтан	11	11	0	100

